

UCS 1205C:2025

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ




Эх, хүүхдийн өрөөг төлөвлөх гарын авлага

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

Эх, хүүхдийн өрөөг төлөвлөх гарын авлага

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/08-р тогтоолоор батлав.



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт	4
4. Эх, хүүхдийн өрөөний төлөвлөлтийн ерөнхий шаардлага.....	5
5. Тэмдэг, тэмдэглэгээ.....	7
6. Тавилга, тоноглолыг ашиглах заавар болон мэдээллийн хэсэг	8
7. Ашиглалт, засвар үйлчилгээ, хяналт	9
8. Шалгах хуудас	9

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийтийн зориулалттай эх хүүхдийн өрөөний харагдах байдал	5
Зураг 2. Эх хүүхдийн өрөөний доторх харагдах байдал	5
Зураг 3. Хаалганы өргөний хэмжээ	6
Зураг 4. Өрөөний таних тэмдэг.....	8
Зураг 5. Эх хүүхдийн өрөөний таних тэмдэг, тэмдэглэгээ	8
Зураг 6. Эх хүүхдийн өрөөний харагдах байдал.....	10
Зураг 7. Эх хүүхдийн өрөөний харагдах байдал.....	11

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эх хүүхдийн өрөөнд шаардлагатай тохог төхөөрөмж, тавилгын жагсаалт	7
Хүснэгт 2. Тавилга, тоноглолын хяналт, үнэлгээ хийх үзүүлэлт	9
Хүснэгт 3. Хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	9



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 25/bs

Улаанбаатар хот

Худалдаа үйлчилгээний газрын гадна
орчинд хамаарах хотын стандартыг
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Худалдаа үйлчилгээний газрын гадна орчин” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS1204B:2025 “Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1205C:2025 “Нийтийн эх, хүүхдийн өрөөг төлөвлөх гарын авлага хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

17.01.2025

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

UCS 1205C:2025

“ЭХ, ХҮҮХДИЙН ӨРӨӨГ ТӨЛӨВЛӨХ ГАРЫН АВЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг албан байгууллага, их дэлгүүр, зах, худалдаа үйлчилгээний нэгдсэн цогцолбор төв, нисэх онгоцны буудал, эмнэлгийн барилга байгууламжид хөхүүл эхийн өрөөг төлөвлөх, зураг төсөл боловсруулахад дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 31-03-03 Олон нийтийн иргэний барилга;
- БНБД 31-01-10 Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт;
- БНБД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм;
- БНБД 31-04-12 Захиргааны зориулалттай олон нийтийн барилга;
- MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага;
- UCS 1001A:2023 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Эх, хүүхдийн өрөө - гэж хүүхдийг хөхөөр хооллох, угжаар хооллох, живхийг солих болон хөхүүл ээжийг хөхөө суллах зориулалт бүхий хувийн орон зайг хангасан, бусдаас тусгаарлагдсан, нэг болон олон хүн зэрэг хэрэглэх боломжтой, зориулалтын тавилга, тоноглолоор тоноглогдсон өрөө;

Эргономик - гэж хүний хөдөлгөөний орон зайнаас хамааруулсан гол хэмжээ;

Антропометр хэмжээ - гэж хүний бие, түүний хэсгүүдийн өөрчлөлтийн системийг заасан гол хэмжээ;

Эрүүл ахуй - гэж хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчноос шалтгаалан эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг тандах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөхцөл, шаардлага;

Хаалганы орон зай - гэж хаалганы хавтас 90 ба бүрэн онгорхой үеийн хаалганы ерөнхий хэмжээ.

4. ЭХ, ХҮҮХДИЙН ӨРӨӨНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Нийтийн эх хүүхдийн өрөө нь хүүхдийг хөхүүлэх, угжих, хуурайлах, мөн хөхүүл эх хөхөө саахад тав тухтай, эрүүл ахуйн шаардлага хангасан орон зайтай байна.
- 4.2. Өрөөний байршил нь барилга, байгууламжийн хамгийн эхний буюу доод давхарт байршуулах эсхүл дээд давхруудад зорчих боломжийг хангасан байх бөгөөд нам гүм орчинд төлөвлөвөл зохино.
- 4.3. Өрөө нь оффис, худалдаа, үйлчилгээний газар байршиж буй бол тухайн барилга байгууламжийн үйл ажиллагаа явуулах цагтай уялдсан байдлаар нээлттэй, үнэ төлбөргүй байна.
- 4.4. Нийтийн эх хүүхдийн өрөө нь олон хэрэглэгчид зориулсан бол хүүхэд хөхүүлэх хэсэг, хүүхэд хуурайлах гэсэн 2 хэсэгтэй байхаар төлөвлөнө.
- 4.5. Өрөө нь олон хэрэглэгчид зориулсан бол өрөөний хэмжээ 15 мкв-аас багагүй байна.
- 4.6. Нэг хэрэглэгчид зориулсан өрөө нь хөхүүл эх хөхөө тайван саах нөхцөлийг бүрдүүлсэн эрүүл ахуйн шаардлага хангасан байх бөгөөд өрөөний хэмжээ 2-5 мкв байна.
- 4.7. Өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдлыг хангасан байх бөгөөд өрөөн дотор тэргэнцэр болон хүүхдийн тэрэг чөлөөтэй эргэх боломжийг бүрдүүлсэн сул зай талбайтай байна.




Зураг 1. Нийтийн зориулалттай эх хүүхдийн өрөөний харагдах байдал (жишээ зураг)

- 4.8. Эх хүүхдийн өрөөний дотор тусгаарлагдсан орон зай нь бүгд түгжих боломжтой, яаралтай үед гаднаас онгойх боломжтойгоор хийгдсэн байна.
- 4.9. Өрөөний өнгийг дулаан, зөөлөн өнгөтэй байхаар төлөвлөвөл зохистой.
- 4.10. Нийтийн эх хүүхдийн өрөөний шал нь халтирдаггүй, галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх бөгөөд хивсгүй байвал зохино.
- 4.11. Эрүүл ахуйн шаардлагыг хангах зорилгоор ариун цэврийн өрөө болон бусад бохирдолтой орчноос тусгаарлагдсан байна.



Зураг 2. Эх хүүхдийн өрөөний доторх харагдах байдал (жишээ зураг)

4.12. Хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдлыг хангасан байх ба UCS 1001A:2023 хотын стандартын дагуу хаалганы өргөн нь 0,9 метрээс багагүй байна.



Зураг 3. Хаалганы өргөний хэмжээ (жишээ зураг)

- 4.13. Нийтийн эх хүүхдийн өрөөний агааржуулалтын системийг барилга байгууламжийн үндсэн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөнө.
- 4.14. Хог түр хадгалах сав нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан UCS 1701A:2022 Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент хотын стандартад нийцсэн байна.
- 4.15. Нийтийн эх хүүхдийн өрөө нь хүүхдийг хөхүүлэх, угжих, хуурайлах, мөн хөхүүл эх хөхөө суллахад тав тухтай эрүүл ахуйн шаардлагыг хангасан дараах тавилга, тоног төхөөрөмжтэй байвал зохино. Үүнд:

Хүснэгт 1. Эх хүүхдийн өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилгын жагсаалт

№	Иж бүрдэл	Зайлшгүй шаардлагатай тоноглол	Нэмэлтээр байршуулах боломжтой тавилга, тоноглол
1	Хөхүүл эх хөхөө суллах, хүүхдийг хөхөө болон угжаар хооллох үед суух зориулалттай тухтай сандал, буйдан	+	
2	Ирмэг дагуу хүүхэд унахаас сэргийлсэн хамгаалалттай, хүүхдийн живх солих ширээ	+	
3	Хөхний сүү саагч болон бусад зориулалтын тоноглол залгах боломжтой цахилгааны залгуур	+	
4	Стандартын шаардлага хангасан угаалтуур	+	
5	Хөхүүл эх болон бага насны хүүхдийн хэрэгсэл, угж гэх мэт зүйл тавих боломжтой жижиг ширээ	+	
6	Угж бэлтгэх зориулалттай халуун хүйтэн цэвэршүүлсэн ус гаргагч	+	
7	Битүүмжлэлтэй, тагтай хүүхдийн живхний хаягдал хийх зориулалттай хогийн сав	+	
8	Гар хатаах зориулалттай гарын цаасны хайрцаг болон үлээгч гэх мэт тоноглол		+
9	Живх солих тавцан болон бусад зүйлсийг ариутгах боломжтой ариутгалын шингэний сав, ариутгагч алчуурын сав		+
10	Сандлын дэргэд хувцас, цүнхний өлгүүр		+
11	Аюулгүй толь		+
12	Угж халаах зориулалттай богино долгионы зуух		+
13	Хөхний сүү хадгалах зориулалттай хөргөгч		+
14	Яаралтай үед тусламж дуудах товч, дохиолол		+

5. ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

- 5.1. Өрөөний байршил, очих чиглэл болон өрөөний гадна тэмдэглэгээг стандартад заасан жишиг зургийн дагуу байршуулна. Үүнд нярай хүүхдийн өрөөний тэмдэглэгээг өрөөний гадна талд болон байршил, замыг заасан хэсгүүдэд байршуулна.
- 5.2. Өрөөний хаяг, тэмдэг, тэмдэглэл нь харагдахуйц тод өнгөөр тэмдэглэсэн байна.
- 5.3. Өрөөний тэмдэглэгээний жишиг загварыг дараах байдлаар ангилна. Үүнд: “Хүүхэд хуурайлах өрөө”, “Хөхүүл эхийн өрөө”.



Зураг 4. Өрөөний таних тэмдэг (жишээ зураг)



Зураг 5. Эх хүүхдийн өрөөний таних тэмдэг, тэмдэглэгээ (жишээ зураг)

5.4. Өрөөний хаалганы цоож нь дотроо үйлчлүүлэгчтэй тохиолдолд улаан, үйлчлүүлэгчгүй тохиолдолд ногооноор тэмдэглэгдсэн, үйлчлүүлэгчдийн тав тухыг хангахуйц байна.

6. ТАВИЛГА, ТОНОГЛОЛЫГ АШИГЛАХ ЗААВАР БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ

- 6.1. Нийтийн эх, хүүхдийн өрөөний тоног төхөөрөмж дээр эсхүл мэдээллийн самбарт хариуцагч байгууллагын нэр, хаяг болон холбоо барих утасны дугаарыг байршуулсан байна.
- 6.2. Нийтийн эх, хүүхдийн өрөөний тавилга, тоноглолыг эзэмшигч болон хариуцагч байгууллага тавилга тоноглолын суурилуулалт, засвар үйлчилгээ, материалын чанар, бусад шаардлагатай мэдээллийг хадгална.
- 6.3. Мэдээллийн самбарт хэрэглэгчдэд өгөх зөвлөгөө, заавар, дүрэм, санамж, сануулга, анхааруулга зэрэг мэдээллүүдийг тусгасан байна.

7. АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ, ХЯНАЛТ

- 7.1. Нийтийн эх хүүхдийн өрөөний тавилга, тоноглолын элэгдэл, эвдрэлээс иргэнд, осол гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор засвар үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол хийнэ.
- 7.2. Нийтийн эх хүүхдийн өрөөний тавилга, тоноглолд хяналт, үнэлгээ хийх үзүүлэлтийг Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Тавилга, тоноглолын хяналт, үнэлгээ хийх үзүүлэлт

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Тавилга, тоноглол бохирдолтой байгаа эсэх	☐	☐
2	Тавилга, тоноглолд цэвэрлэгээ хангалттай хийгдсэн эсэх	☐	☐
3	Тавилга, тоноглол нь эвдэрч гэмтсэн, хугарсан эсэх	☐	☐
4	Тавилга, тоноглол нь бүрэн ажиллагаатай байгаа эсэх	☐	☐
5	Тавилга, тоноглол дээрх ашиглагчдад тавигдах шаардлага тодорхой харагдаж байгаа эсэх	☐	☐

Тайлбар: Тоног төхөөрөмж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.



8. ШАЛГАХ ХУУДАС

Нийтийн эх, хүүхдийн өрөөний тавилга тоноглолын материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 3. Хүлээн авах шалгуур үзүүлэлт


№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Нийтийн эх, хүүхдийн өрөө төлөвлөлтийн дагуу хийгдсэн эсэх	☐	☐
2	Нийтийн эх, хүүхдийн өрөөний тавилга, тоноглолыг зөв байрлалд, зөв байршуулсан эсэх	☐	☐
3	Нийтийн эх, хүүхдийн өрөөний тавилга, тоноглолыг үйлдвэрлэгчийн заавар, стандартын шаардлагын дагуу суурилуулсан эсэх	☐	☐
4	Нийтийн эх, хүүхдийн өрөөний тавилга, тоноглолын материал чанарын шаардлага хангаж байгаа эсэх	☐	☐
5	Нийтийн эх, хүүхдийн өрөөний тавилга, тоноглол нь чанарын баталгаа, гарал үүслийн гэрчилгээтэй эсэх	☐	☐

ХАВСРАЛТ 1. АЖЛЫН БАЙРАНД ДАХЬ ХӨХҮҮЛ ЭХЭД ЗОРИУЛСАН ӨРӨӨ



Зураг 6. Эх хүүхдийн өрөөний харагдах байдал (жишээ зураг)

ХАВСРАЛТ 2. ОЛОН ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЭХ ХҮҮХДИЙН ӨРӨӨ



Зураг 7. Эх хүүхдийн өрөөний харагдах байдал (жишээ зураг)



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар